

181

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны 02 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар А/20 - А/58

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, Зэвсэгт хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.14, 14.2.16 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.4, 5.5.2, 5.5.10-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төмөр замын бүтээн байгуулалтын ажилд цэргийн алба хаагчид оролцож байгаатай холбогдуулан “Цэргийн алба хаагчдад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батбилэг/ нарт даалгасугай.

3. Сургалтыг журмын дагуу зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв /Ц.Батдорж/, Зэвсэгт хүчний Жанжин штабын сургалтын хэлтэс болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирал нарт тус тус үүрэг болгосугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД




С.ЧИНЗОРИГ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД



Н.ЭНХБОЛД



ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд төмөр зам тавих, цаашид Улс орны бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд цэргийн алба хаагчдыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага /цаашид сургалтын байгууллага гэх/-д суралцуулж мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Зэвсэгт хүчний Жанжин штабын захиалгаар цэргийн алба хаагчдыг сургалтын байгууллагад 4-6 хүртэлх сарын хугацаатайгаар суралцуулан мэргэжил, ур чадвар эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Цэргийн алба хаагчдыг мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад бүртгэх

2.1. Сургалтад хамрагдах цэргийн алба хаагчдыг сонгох, бүртгэх ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб зохион байгуулна.

2.2. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь улс орны бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжлээр цэргийн алба хаагчдыг бэлтгэх санал, захиалгыг жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн санал, захиалгыг сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоо, мэргэжлийн чиглэлд тусган батална.

2.4. Сургалтад хамрагдах цэргийн алба хаагч дараах бичиг баримтыг бүрдүүлж бүртгүүлнэ. Үүнд:

- Өргөдөл;
- Иргэний үнэмлэхний хуулбар;
- Цээж зураг 1 хувь;
- Боловсролын бичиг баримтын хуулбар.

2.5. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь элсэгчдийн мэдээллийг “Маягт-1”-ийн дагуу гарган сургалтын байгууллагад жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.6. Сургалтын байгууллага элсэлтийн мэдээг “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”-ын дагуу холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Сургалт зохион байгуулах

3.1. Сургалтыг 4-6 хүртэлх сарын хугацаанд онол, дадлагын харьцаа 20:80 /±5/ байхаар тусгай хөтөлбөрөөр зохион байгуулна.

3.2. Сургалтыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй сургалтын байгууллагууд холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулна.

3.3. Сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үйлдвэрлэлийн дадлагын удирдамж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны дагуу сургалт, дадлагын ажлыг зохион байгуулна.

3.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5 дахь хэсэгт тусгагдсаны дагуу үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулна.

3.5. Үйлдвэрлэлийн дадлагыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын материаллаг баазыг түшиглэн Зэвсэгт хүчний Жанжин штаб, сургалтын байгууллага хамтран чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

3.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сургалтын байгууллагын хүлээх үүрэг:

3.6.1. Сургалтын үйл ажиллагааг батлагдсан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.6.2. Үйлдвэрлэл, сургалтын дадлагын үйл ажиллагааг сургалтын байгууллагын дадлагын орчныг түшиглэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

3.6.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1-д заасан журмыг үндэслэн төгсөгчдөд бичиг баримт олгох;

3.6.4. Сургалтын байгууллагад суралцаж байгаа цэргийн алба хаагчдад “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын дагуу тэтгэлэг олгохыг хариуцах;

3.7. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штабын хүлээх үүрэг:

3.7.1. Үйлдвэрлэл, сургалтын дадлагын үйл ажиллагааг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагын дадлагын орчныг түшиглэн төлөвлөгөөний дагуу сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.7.2. Цэргийн алба хаагчдыг суралцах хугацаанд нь сургалтын байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хооронд тээвэрлэх асуудлыг хариуцах;

3.7.3. Суралцах хугацаанд цэргийн алба хаагчдыг хооллох болон хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн асуудлыг хариуцах;

3.7.4. Төгсөгчдийг шууд ажлын байраар хангах, зуучлах ажлыг хариуцан зохион байгуулна.

Дөрөв. Төгсөгчдийн ур чадварыг үнэлэх, бичиг баримт олгох

4.1. Төгсөлтийн үнэлгээг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан журмыг үндэслэн сургалтын байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штабтай хамтран зохион байгуулна.

4.2. Төгсөгчдөд мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олгоно.

4.3. Сургалтын байгууллага нь төгсөгчдийн тоо болон төгсөлтийн бичиг баримтын захиалгыг төгсөх хугацаанаас 21 хоногийн өмнө "Маягт-2"-ын дагуу гарган Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Тав. Сургалтын санхүүжилт

5.1. Сургалтад зориулагдсан зардал нь дор дурдсан эх үүсвэрээс санхүүжнэ. Үүнд:

5.1.1. Улсын төсөв;

5.1.2. Бусад эх үүсвэр;

5.2. Сургалтад дараах зардлууд хамаарна. Үүнд:

5.2.1. Засгийн газраас тогтоосон цалингийн шатлалд нийцүүлэн багшид цалин олгоно.

5.2.2. Үйлдвэрлэлийн дадлагатай холбогдон гарах зардлыг сургалтын байгууллагын үйлдвэрлэлийн дадлагад зарцуулах материалын тооцоог үндэслэн Зэвсэгт хүчний Жанжин штаб олгоно.

5.2.3. Төгсөгчдөд олгох бичиг баримтын зардлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб хариуцна.

5.3. Үйлдвэрлэлийн дадлагатай холбогдон гарч болзошгүй нэмэгдэл зардлыг сургалтын байгууллагын үйлдвэрлэл, сургалтын дадлагын холбогдох материалыг үндэслэн тооцно.

Зургаа. Хэрэгжилтийг тайлагнах, хяналт тавих

6.1. Элсэлт, сургалт, төгсөлтийн мэдээ, тайлан, судалгааг сургалтын үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллага нь Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад зохих журмын дагуу хугацаанд нь ирүүлнэ.

6.2. Журмын хэрэгжилтийн явц, үр дүнд Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Зэвсэгт хүчний Жанжин штаб хяналт тавьж ажиллана.

6.3. Энэхүү журмыг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн 5 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

6.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага харилцан тохиролцсоноор журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.5. Энэхүү журамд заагдаагүй бусад асуудлыг хамтын ажиллагааны гэрээгээр зохицуулж болно.

---oOo---

Мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх
сургалтад хамрагдах цэргийн алба хаагчдын мэдээлэл
..... МСҮТ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

20.. оны ... дугаар сарын ... -ны өдөр

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Мэргэжлийн нэр	Үндсэн харъяалал	Харъяалагдах цэргийн анги нэгтгэл
1						
2						
3						
...						

Судалгаа гаргасан:

.....
/албан тушаал/

.....
/гарын үсэг/

.....
/овог, нэр/

Хянасан:

.....
/албан тушаал/

.....
/гарын үсэг/

.....
/овог, нэр/

Цэргийн алба хаагчдад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх
сургалт зохион байгуулах ажлын хүрээнд
.....МСҮТ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ /доогуур зурах/
Сургалтад хамрагдсан цэргийн алба хаагчдын
төгсөлтийн талаарх мэдээлэл

20... оны дугаар сарын-ны өдөр

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Мэргэжлийн нэр	Үндсэн харъяалал	Олгох бичиг баримт
1						
2						
3						
...						

Судалгаа гаргасан:

Сургалтын албаны дарга

.....
/гарын үсэг/

.....
/овог, нэр/

Хянасан:

Захирал

.....
/гарын үсэг/

.....
/овог, нэр/